



BE ALWAYS CONNECTED WITH  
YOUR LAWYER

Address: Ulaanbaatar, Chingeltei district, 3<sup>th</sup> khoroo,  
Pearl tower, A block-1201; Tel.: 77041414; Email:  
[contact@akp.mn](mailto:contact@akp.mn)

## LEGAL NEWSLETTER

2024 он 02-р сар №42

### Нэг. Батлагдсан хуулийн нэмэлт, өөрчлөлт

"Цахим үндэстэн" болох зорилгыг хэрэгжүүлэх дижитал дэд бүтцийн бэлэн байдлыг хангах, цахим засаглалыг хөгжүүлэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэх зорилгынхоо хүрээнд 100 гаруй хуульд нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Тухайлбал, төрийн байгууллагад өргөдөл, гомдол, санал хүсэлтийг бичгээр болон цахим хэлбэрээр хүлээн авах эрх зүйн орчныг бүрдүүлсэн ба төрийн байгууллагаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад мэдэгдлийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр хүргүүлэх тухай нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Үүнээс онцлох нэмэлт, өөрчлөлтийг танилцуулбал:

#### Захиргааны ерөнхий хуульд орсон нэмэлт, өөрчлөлт:

- Захиргааны байгууллага хуульд өөрөөр заагаагүй бол дараах тохиолдолд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хүсэлт гарган бусад захиргааны байгууллагаас туслалцаа авч болно.
- Гомдлыг хянан шийдвэрлэсэн захиргааны байгууллага энэ тухай захиргааны акт гарсан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор гомдол гаргагч этгээдэд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэж, түүнийг баримтжуулна.

#### Иргэний хуульд орсон нэмэлт, өөрчлөлт:

- Төлөөлүүлэгч нь төлөөлөгч болон түүнтэй хэлцэл хийх гуравдагч этгээдэд төлөөлүүлэх тухайгаа болон төлөөлөгчийн бүрэн эрхийн талаар амаар эсхүл бичгээр эсхүл цахим хэлбэрээр мэдэгдсэнээр төлөөлөгчид бүрэн эрх олгож болно.
- Цахим хэлбэрээр олгосон итгэмжлэл нь энэ хуулийн 64.2-т заасан шаардлагаас гадна Цахим гарын үсгийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан байна.

- Хөлсөөр ажиллах гэрээний харилцааг дуусгавар болгох үед ажиллагч нь ажиллуулагчаас хөлсөөр ажиллаж байсан тухай болон түүний үргэлжилсэн хугацааны талаар бичгээр эсхүл цахим хэлбэрээр тодорхойлолт гаргаж өгөхийг шаардах эрхтэй.

#### Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд орсон өөрчлөлт:

- Хуульч нь хууль зүйн асуудлаар амаар эсхүл бичгээр, эсхүл цахим хэлбэрээр лавлагаа, зөвлөгөө өгөх мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэн явуулна.
- Хуульчдын их хурлын төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаанаар Хуульчдын их хуралд хүрэлцэн ирэх боломжгүй бол саналаа бичгээр эсхүл цахим хэлбэрээр битүүмжлэн ирүүлж болно.

#### Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт:

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн “Сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах” гэсэн 31.5 дугаар зүйлийг “Сэжигтнийг хойшлуулшгүйгээр баривчлах” болгон бүхэлд нь өөрчлөн найруулжээ.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих саналыг шийдвэрлэх шүүхийн харьяаллыг тухайлан хуульчлаагүй тул сэжигтнийг баривчлах, цагдан хорих зөвшөөрөл олгох шүүхийн харьяаллыг шүүхийн практик өөр өөрөөр тайлбарлаж хэрэглэх, оролцогч шүүхийн харьяалалтай холбогдуулан шүүгч, шүүхээс татгалзан гаргах зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүндрэл учруулдаг байсан.

Ийнхүү сэжигтнийг баривчлах, яллагдагчийг цагдан хорих саналыг шийдвэрлэх шүүхийн харьяаллыг нарийвчлан тогтоосноор сэжигтэн, яллагдагчийн шүүхэд хандах эрхийг хамгийн богино хугацаанд, шуурхай хангах боломж бүрдэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа цаашид хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлсэн. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийг 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө.

## Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд оруулсан нэмэлт:

2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд Долдугаар1 бүлэг буюу “Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа”-г шинээр баталсан.

Шүүгч нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 20 дахин нэмэгдүүлснээс дээшгүй үнийн дүнтэй мөнгөн хөрөнгө гаргуулах дараах нэхэмжлэлийг дангаар тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ.

- бүх төрлийн гэрээний дагуу мөнгөн хөрөнгө гаргуулах;
- дундын өмчийн ашиглалт, засвар үйлчилгээтэй холбогдсон зардал гаргуулах;
- хөдөлмөрийн гэрээний дагуу цалин хөлс гаргуулах;
- бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд гэм хор учруулсны улмаас мөнгөн хөрөнгө гаргуулах.

Эдгээр төрлүүдээс гадна Дараах нэхэмжлэлийг үнийн дүнгээс үл хамааран шүүх тусгайлсан журмаар хянан шийдвэрлэнэ:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх зорилгоор эд хөрөнгө, эрхийг битүүмжлэх, хураах, үнэлгээ тогтоох, албадан дуудлага худалдаа явуулах ажиллагаатай холбоотой гомдол;
- Гэрээний үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах нэхэмжлэл;
- Ажилд эгүүлэн тогтоосон хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг үндэслэн ажилгүй байсан хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх олговор гаргуулах нэхэмжлэл.

**\*\*** Гэр бүл, өв залгамжлалын холбогдолтой бүх төрлийн хэрэгт тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх журам үйлчлэхгүй.

- ❖ Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаанд хэргийг нэг шүүх хуралдаанаар, бичмэл болон цахим баримтад тулгуурлан шийдвэрлэх ба иргэний хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 45 хоног, давж заалдах шатны шүүхээс хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан бол шүүгч хэргийг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор тус тус шийдвэрлэнэ.

*\*\*\* Уг Хууль, эрх зүйн мэдээлэл нь албан ёсны хууль зүйн зөвлөгөөнд хамаарахгүй бөгөөд зөвхөн нийтийн мэдээлэл хүргүүлэх зорилготой болно*

### **ALISON & KATE PARTNERS**

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Pearl tower A блок 1201 тоот  
Web: [www.akp.mn](http://www.akp.mn)  
E-mail: [contact@akp.mn](mailto:contact@akp.mn)  
Tel: 7704-1414, 9511-3680